

**ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ
БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ХУУЛЬ,
ДҮРЭМ, ЖУРАМ**

ХАБЭА-н хууль, дүрэм, журам

- ▶ **Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудлыг зохицуулдаг гол хуулиуд**
 1. Хөдөлмөрийн тухай хууль
 2. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй хууль

- ▶ **Хөдөлмөрийн эрүүл ахуйн асуудлыг зохицуулахад оролцдог бусад хуулиуд**
 1. Нийгмийн даатгалын тухай хууль
 2. Нийгмийн даатгалын сангаас үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль
 3. Нийгмийн даатгалын сангаас олгох, тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль
 4. Төрийн хяналт шалгалтын тухай хууль
 5. Зөрчлийн тухай хууль
 6. Эрүүл ахуйн тухай хууль
 7. Эрүүл мэндийн тухай хууль
 8. Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль
 9. Хэмжил зүйн тухай хууль

ХАБЭА-н хууль, дүрэм, журам

▶ Олон улсын гэрээ

1. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай олон улсын хөдөлмөрийн байгууллагын 155 дугаар конвенц
2. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай 164 дүгээр зөвлөмж
3. Уурхай дахь аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай” олон улсын хөдөлмөрийн байгууллагын 176 дугаар конвенцид
4. Хөдөлмөрийн эрүүл мэндийн үйлчилгээний тухай Олон улсын хөдөлмөрийн байгууллагын 161 дүгээр конвенц

▶ Монгол Улсын Засгийн газрын тогтоол

1. **“Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх дүрэм”** Засгийн газрын 269 дүгээр тогтоол
2. **“Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын шимтгэлийг төлөх ажил олгогчийн жагсаалт батлах тухай”** Засгийн газрын 142 дугаар тогтоол

ХАБЭА-н хууль, дүрэм, журам

▶ Сайдын тушаал

1. “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн 2021-2025 оны үйл ажиллагааны хөтөлбөр”
2. “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт зохион байгуулах, шалгалт авах журам батлах тухай” Хөдөлмөрийн сайдын А/370 дугаар тушаал
3. “Аж ахуйн нэгж байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөлийн үлгэрчилсэн дүрэм” Хөдөлмөрийн сайдын А/114 дүгээр тушаал
4. “Ажлын байрны нөхцөлийн үнэлгээ хийх журам” Хөдөлмөрийн сайдын А/223 дугаар тушаал
5. “Ажлын байрны эрсдэлийн үнэлгээ хийх аргачилсан зөвлөмж” Хөдөлмөрийн сайдын А/295 дугаар тушаал
6. “Аж ахуйн нэгж байгууллагын үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх орон тооны бус байнгын комиссын ажиллах заавар” /аргачилсан зөвлөмж/ Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын А/36 дугаар тушаал
7. “Эрүүл-Аюулгүй ажлын байрыг эрхэмлэгч байгууллага шалгаруулах журам батлах тухай” Хөдөлмөрийн сайдын А/61 дүгээр тушаал
8. “Мэргэжлээс шалтгаалах өвчнийг бүртгэх, мэдээллэх журам” Хөдөлмөрийн сайдын А/234 дүгээр тушаал

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаарх хууль эрх зүй

9. “Журам, жагсаалт батлах тухай” Эрүүл мэндийн сайдын А/340 дүгээр тушаал

- Эрүүл мэндийн урьдчилсан болон хугацаат үзлэгийн журам Хавсралт 1
- Хөдөлмөрийн нөхцлөөс хамааран эрүүл мэндийн үзлэг хийх жагсаалт Хавсралт 2
- Ажил мэргэжлээс шалтгаалан эрүүл мэндийн үзлэг хийх жагсаалт Хавсралт 3
- Ажил, мэргэжлээс шалтгаалан эрүүл мэндийн үзлэг хийсэн тухай тайлан Хавсралт 4

10. “Тэтгэврийг хөнгөлөлттэй нөхцөлөөр тогтоох газрын дор болон хөдөлмөрийн хортой, халуун, хүнд нөхцөлд хамаарах ажил мэргэжлийн жагсаалт батлах тухай” Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 77 дугаар тушаал

11. “Тэтгэврийг хөнгөлөлттэй нөхцлөөр тогтоох газрын дор болон хөдөлмөрийн хортой, халуун, хүнд нөхцөлд хамаарах ажил мэргэжлийн жагсаалтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын А/12, А/26 дугаар тушаал

12. “Тэтгэврийг хөнгөлөлттэй нөхцлөөр тогтоох газрын дор болон хөдөлмөрийн хортой, халуун, хүнд нөхцөлд хамаарах ажил мэргэжлийн жагсаалтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Хөдөлмөрийн сайд, Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдын хамтарсан А/133, А/77 дугаар тушаал

13. “Насанд хүрээгүй хүнийг ажилууллахыг хориглосон ажлын байрны жагсаалт батлах тухай” Хөдөлмөрийн сайдын А/36 дугаар тушаал

14. “Бичил уурхай аюулгүй байдлын дүрэм” Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд, Уул уурхай, хүнд үйлдвэрлэлийн сайд нарын А/115, А/123 дугаар хамтарсан тушаал

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаарх хууль эрх зүй

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үндэсний хороо, нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоол

1. **“Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үндэсний хороог шинэчлэн байгуулах, дүрмийг батлах тухай”** Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт үндэсний хорооны 05 дугаар тогтоол
2. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн салбар хороо, аймаг, нийслэл, дүүргийн ХАБЭА-н Үндэсний хорооны 04 дүгээр тогтоол
3. **“Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийх аргачилсан зөвлөмж батлах тухай”** Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн Үндэсний хорооны 01 дүгээр тогтоол
4. **“Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлыг санхүүжүүлэх журам”** Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 10 дугаар тогтоол

Бусад

1. **“Үйлдвэрлэл, үйлчилгээний машин механизм, тоног төхөөрөмжид гэрчилгээ олгох журам”** Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын А/181 тоот тушаал
2. **“Барилгын дүрэм батлах тухай”** Барилга хот байгуулалтын сайдын А/133 дугаар тушаал
3. **“Галын аюулгүй байдлын дүрэм”** Засгийн газрын 339 дүгээр тогтоол

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн 2021-2025 оны үйл ажиллагааны хөтөлбөр

1. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн **хууль эрх зүйн орчныг** боловсронгуй болгож, уялдаа холбоог нь сайжруулна.
2. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн **удирдлага зохион байгуулалт, хамтын ажиллагааг** сайжруулна.
3. Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний урьдчилан сэргийлэлтэд **хөдөлмөрийн хяналтын үр нөлөөг** сайжруулна.
4. Аж ахуйн нэгж байгууллагын түвшинд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн **удирдлагын тогтолцоог** боловсронгуй болгож, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний **урьдчилан сэргийлэлтийг** сайжруулна.
5. **Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн боловсрол, сургалт, статистик эрдэм шинжилгээнд** дэмжлэг үзүүлнэ

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль:

- ▶ ХАБЭА-н тухай бие даасан хууль 2008 оны 5 дугаар сарын 22-нд батлагдсан.
- ▶ 9 бүлэг 37 зүйлтэй.
- ▶ 7 удаа нэмэлт өөрчлөлт орсон.
 - 2011-01-20 /Хөдөлмөрийн нөхцөл, хамгаалах хэрэгсэл/
 - 2012-12-21 /Аймаг, нийслэл, сум, дүүрэг, хорооны ХАБЭА-н асуудал хариуцсан ажилтантай холбоотой өөрчлөлт/
 - 2015-05-14
 - 2015-12-04 /Галын аюулгүй байдлыг хангах талаарх эрх, үүрэг, хариуцлага/
 - 2016-09-01, 2018-06-27 Хуулийн үйлчлэх хүрээ /хугацаат ба цэргийн гэрээт алба хаагч, дайчилгааны сургууль, цугларалтад оролцож байгаа цэргийн үүрэгтэн/
 - 2021-07-02 /Хөдөлмөрийн хуулийн шинэчлэлттэй холбоотой өөрчлөлт/

Хуулийн үйлчлэх хүрээ

- ▶ Ажил олгогч, ажилтан
- ▶ Хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн;
- ▶ Иргэд хоорондын гэрээгээр ажиллагчид
- ▶ ААНБ-д үйлдвэрлэлийн дадлага хийж байгаа их, дээд сургууль, коллеж, МСҮТ-ийн суралцагч, цэргийн сургуулийн сонсогч
- ▶ Хугацаат ба гэрээт цэргийн жинхэнэ албан хаагч, дайчилгааны сургууль, цугларалтад оролцож байгаа цэргийн үүрэгтэн;
- ▶ Хоршоо, нөхөрлөлийн гишүүд;
- ▶ Ял эдэлж байгаа хоригдол
- ▶ Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа гадаадын ААНБ-д ажилладаг МУ-ын иргэн, гадаадын болон харьяалалгүй иргэн.
- ▶ Хамтран ажиллах, ажил гүйцэтгэх гэрээний үндсэн дээр болон бусад хэлбэрээр ажил, хөдөлмөр эрхэлж буй МУ-ын, гадаадын иргэн, харьяалалгүй иргэн.

Ажил олгогч нь

- ❖ ХАБ-ыг хангах, хөдөлмөрийн нөхцлийг сайжруулах, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, хяналт тавих үүргийг ААНБ-ын дарга, захирал /эзэн/ шууд хариуцна. /ХАБЭА тухай хууль 27.1 /
- ❖ ААНБ-ын **хэлтэс, албаны дарга, нэгж тасгийн ахлагч нар** өөрийн ажлын байранд тохирсон дүрэм журам боловсруулахад оролцох, үр дүнг тооцох, хяналт тавих, манлайлан ажиллах, аюулыг илруулэх арилгах талаар мэдээлэх, ХАБЭА-н ажилтантай хамтран ажиллах /ХАБЭА тухай хууль 27.5 /
- ❖ ХАБЭА хариуцсан ажилтнаар **инженер, техникийн болон эрүүл ахуйчаар** мэргэшсэн хүнийг ажиллуулна. /ХАБЭА тухай хууль 27.3.5/
- ❖ ААНБ-уудад **ХАБЭА-н асуудал хариуцсан орон тооны ажилтан, зөвлөл** заавал ажиллуулж байхаар тусгасан. / ХАБЭА-н тухай хууль 27.2, Хөдөлмөрийн сайдын А/114 тоот тушаал/

Ажил олгогчийн үүрэг /хуулийн 28-р зүйл/

- 28.1.3. Хөдөлмөр эрхлэлтийн явцад гарч болзошгүй осол, бэртэл, өвчлөлөөс ажилтныг хамгаалах **хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн удирдлагын тогтолцоог нэвтрүүлэх;**
- 28.1.4. Ажлын байранд учирч болох аюул ослыг арилгах, хяналт тавих зорилгоор **эрсдэлийн үнэлгээ хийх;**
- 28.1.5. Ажлын байрны **хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээг хийлгэх;**
- 28.1.6. Ажлын байрны онцлогт нийцсэн **дүрэм, заавар, журам баталж, мөрдүүлэх;** /16 үүрэг, 4 эрх бий/

Ажил олгогч нь

- ❖ Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин, хурц хордлогын улмаас хөдөлмөрийн чадвараа алдсан ажилтанд хууль тогтоомжийн **дагуу нөхөн төлбөр олгох** /Хөдөлмөрийн тухай хууль 97.1, ХАБЭА тухай хууль 28.1.15/
- ❖ Төсвийн байгууллага нь батлагдсан төсвийн 0,5 хувиас, **ААНБ-ууд эрсдлийн түвшингээс хамааран үйлдвэрлэл үйлчилгээний зардлын 1,5 хувиас** доошгүй хэмжээний хөрөнгийг ХАБЭМ-ийн чиглэлийн үйл ажиллагаанд зарцуулахаар тусгасан байдаг. /ХАБЭА тухай хууль 26.2/

Ажилтны эрх:

- ❖ ХАБЭА-н шаардлага хангасан ажлын байранд ажиллах
- ❖ ҮО, МШӨ-ний даатгалд хамрагдах
- ❖ Ажлын байрны нөхцөл, эрүүл мэндэд учирч болох **эрсдэл, сөрөг хүчин зүйлийн талаар бодит мэдээлэл авах, асуудал үүссэн тохиолдолд ажлаа зогсоох** ажил олгогчид мэдэгдэх
- ❖ **ХАБЭА-н асуудал хэлэлцэхэд** өөрөө болон төлөөлөгчөөрөө дамжуулан **оролцох** саналаа илэрхийлэх /ХАБЭА тухай хууль 18 дугаар зүйлийн 1/

Ажилтны үүрэг:

- ❖ ХАБЭА–н шаардлага, стандарт, дүрэм, технологийн горимыг чанд мөрдөх, өгөгдсөн шаардлагыг биелүүлж ажиллах
- ❖ ХАБЭА сургалтанд хамрагдсан байх, аюулгүй ажиллагааны заавар авсан байх
- ❖ Аюултай нөхцөл бий болсон бол аюулгүй байдлын дүрэм журмын дагуу шуурхай арга хэмжээ авах
- ❖ ЭМ-ийн үзлэгт хамрагдах
- ❖ Анхны тусламж үзүүлэх чадвар эзэмшсэн байх
- ❖ Өөрийгөө болон бусдыг эрсдэлд учруулахгүй байх

/ХАБЭА тухай хууль 18 дугаар зүйлийн 2/

ХАБЭА-н холбогдолтой тогтоол, тушаал, дүрэм, заавар, журам

- ▶ **“Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх дүрэм”** Монгол улсын Засгийн газрын 269 дүгээр тогтоол. 2015.06.29.
- ▶ **“ХАБЭА-н зөвлөл байгуулах, орон тооны ажилтан ажиллуулах норматив батлах тухай”** Хөдөлмөрийн сайдын 114 дүгээр тушаал. 2015.06.22.
- ▶ **“Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийх журам”** “Журам шинэчлэн батлах тухай” Хөдөлмөрийн сайдын 223 дугаар тушаал. 2015.11.13
- ▶ **“Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээний тарифийг шинэчлэн батлах тухай”** Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын А/74 дүгээр тушаал. 2019.03.04
- ▶ **“Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт зохион байгуулах, шалгалт авах журам батлах тухай”** Хөдөлмөрийн сайдын А/370 дугаар тушаал. 2019.12.13
- ▶ **“Барилгын ажилд ХАБЭА-н шаардлагыг хангуулах нийтлэг журам”** Хөдөлмөрийн болон Барилга, хот байгуулалт, Засгийн газрын шадар сайдын хамтарсан А/82 дугаар тушаал. 2015.7 сар

**“ХАБЭА-н зөвлөл байгуулах, орон тооны ажилтан ажиллуулах норматив батлах тухай”
Хөдөлмөрийн сайдын 114 дүгээр тушаал. 2015.06.22**



“Журам шинэчлэн батлах тухай”

Хөдөлмөрийн сайдын 223 дугаар тушаал. 2015.11.13

“АЖЛЫН БАЙРНЫ ХӨДӨЛМӨРИЙН НӨХЦӨЛИЙН ҮНЭЛГЭЭ ХИЙХ ЖУРАМ”

- ▶ **Ажил олгогч нь жилд нэгээс доошгүй удаа ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээг дараахь нөхцөлд хийлгэнэ. /ХАБЭА-н тухай хуулийн 31.2-д/**
 - ▶ Ажлын байр шинээр бий болгосон,
 - ▶ Тухайн ажлын байрны үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэл, нөхцөл өөрчлөгдөх бүрт нь,
 - ▶ Химийн хорт болон аюултай бодис агуулсан түүхий эд, материал ашиглан үйл ажиллагаа явуулж байгаа бол
- ▶ **31.1. Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээг стандартын асуудал эрхэлсэн байгууллагын итгэмжлэл бүхий мэргэжлийн байгууллага батлагдсан журмын дагуу хийнэ.**
- ▶ **28.1.5. Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээг хийлгэх үүргийг ажил олгогч хүлээнэ.**
- ▶ **Итгэмжлэл бүхий байгууллага ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийсэн тухай холбогдох тайлан, дүгнэлт, зөвлөмжийг тухайн байгууллагын ажил олгогчид ажил гүйцэтгэх гэрээнд заасан хугацаанд өгнө. ХЭМСТ-д дүгнэлт гарсны дараа ажлын 5 хоногийн дотор нэг хувийг хүргүүлнэ.**
- ▶ **“Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээний тарифийг шинэчлэн батлах тухай” Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын А/74 дүгээр тушаал. 2019.03.04**

“Химийн бодистой харьцаж ажилладаг ажилтанд олгох хор саармагжуулах хүнсний бүтээгдэхүүний жагсаалт батлах тухай”

Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын 171 дүгээр тушаал. 2000.06.19

№	Ерөнхий нэр	Түүнд хамаарагдах бодисууд	Олгож болох хүнсний бүтээгдэхүүн
1	Ханасан ба ханаагүй нүүрстөрөгч	Метан, этан, пропан, бутан, этилен, бутилен, пропилен, амилен, ацетилен г.м хоёрлосон ба гурвалсан холбоотой нэгдлүүд	Сүү, витаминжуулсан ундаа
2	Ханаагүй аллицикел нэгдлүүд	Циклопентден, винилциклогексон, этилфиглогексан	Чихэртэй цай, витаминжуулсан ундаа
3	Холимог нүүрстөрөгч	Озокерит, тазут, битум, асфальт давирхай, тослогч материал, парафин, изопрафин, керосин, чулуун нүүрсний давирхай пек кокс	Витамин С, сүү, витаминжуулсан ундаа
4	Ароматик нэгдлүүд	Бензол, толуол, стирол, ксилол, этилбензил, пропилбензол, этилтолуол, диэтилтолуол, метилстирол, холимог ароматик нэгдлүүд	Чихэртэй цай, сүү, витаминжуулсан ундаа
5	Ууршигтгай эргэж буудаг ба буудаггүй цагираг нүүрстөрөгч, үнэрт нэгдлийн холимог	Нафталин, антрацен, пирен, фенол	Чихэртэй цай, сүү, витаминжуулсан ундаа
6	Галогений органик нэгдлүүд	4 хлорт нүүрстөрөгч, дихлорэтан, хлорформ, хлортэтил, дихлорэтан, трихлорвинил, дихлорвинил, гексахлор, гексахлоргексан, гексахлор будатиен, дихлор ацетилен	Тараг, чихэртэй цай, сүү, витаминжуулсан ундаа, /спиртлэг зүйлийг хориглоно/
7	Циклобром, хлор органик нэгдлүүд	-	Сүү, шүлтлэг ундаа
8	Хлорт цагираг, үнэрт нэгдлүүд	Кельтан, ДДТ, формилин, пертан,, метаксилхор, тиодин, хлорнафталин	Тос багатай сүү, өндөг, загас, В витаминь комплекс
9	Спиртүүд	Метил, этил, бутил, пропилийн спиртүүд диэтилгликоль	Содтой халуун сүү, цай, кофе
10	Фенолууд	Фенол, хлорфенол, пентахлорфенол, ксимнол, гидрохинон	Сүү
11	Эфирүүд	Этилийн, диэтилийн, дипропилийн, дибутилийн, дивинилийн эфирүүд	Цай, сүү, кофе
12	Хэт ислүүд ба органик ислүүд	Окись этилен, окисметилен, окись пропилен	Витаминжуулсан ундаа, тараг
13	Нитроциклогексан, тосны эгнээний амин нэгдлүүд	Метиламин этиламин, диметиламин, триметиламин, триэтиламин, пропиламин, дипропиламин, изопропиламин, этилендиамин, ундецикламин, диэтилтриамин, ксилалендизмин	Сүү

Нисэхийн сургалтын төв

“Ажлын тусгай хувцас хамгаалах хэрэгслийн үлгэрчилсэн жагсаалт батлах тухай”

Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 122 дугаар тушаал. 2002.12.12

№	Ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгсэл олгох нөхцөл	Олгох ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслийн нэр төрөл
A	1	2
1	Механик үйлчлэлтэй нөхцөл А.Хурц ирмэг, үзүүртэй биет юмстай буюу арзгар гадаргуутай харьцах	1. Ажлын бээлий /алгандаа хамгаалалт буюу зөөлөвчтэй/ 2. Ажлын гутал 3. Ажлын өмд, цамц 4. Каск /дуулга/ 5. Хамгаалалтын нүдний шил
	Б.Үрэлт чичиргээ доргионтой	1. Ажлын бээлий /алгандаа хамгаалалт буюу зөөлөвчтэй/ 2. Ажлын өмд, цамц 3. Ажлын гутал 4. Хормогч 5. Каск /дуулга/
	В.Уналт, нуралт цохилттой	1. Каск /дуулга/ 2. Ажлын өмд, цамц 3. Ажлын тусгай хувцас 4. Нүдний шил
2	Хальтиргаатай нөхцөлд: тослог, мөслөг гадаргуутай харьцах	1. Ажлын тусгай гутал 2. Ажлын бээлий 3. Каск /дуулга/
3	Халуун нөхцөлд А.Оч, ил задгай гал хайлштай харьцах	1. Галд тэсвэртэй материалаар хийгдсэн өмд, цамц 2. Галд тэсвэртэй материалаар хийгдсэн малгай 3. Галд тэсвэртэй материалаар хийгдсэн ажлын бээлий 4. Нүүр хамгаалах баг буюу нүдний шил 5. Ажлын тусгай гутал
	Б.Дулаан ялгаруулдаг гадаргуутай харьцах	1. Дулаанд тэсвэртэй материалаар хийгдсэн өмд, цамц 2. Дулаанд тэсвэртэй материалаар хийгдсэн малгай 3. Дулаанд тэсвэртэй материалаар хийгдсэн бээлий 4. Ажлын тусгай гутал

4	Хүйтэн нөхцөлд: Гадаа буюу хүйтэн байранд байнга ажиллах болон бэлчээрийн мал маллах	1. Дулаалгатай өмд, цамц 2. Ажлын дулаалгатай гутал 3. Дулаалгатай бээлий 4. Бэлчээрийн мал маллах үед буюу отроор явахад нэмэлт үстэй дээл буюу дах дэгтий 5. Өвлийн үед бууралттай нүдний шил 6. Буулгадаг малгай	
5	Хурц гэрэлтэй	1. Бууралттай нүдний шил 2. Тусгай эдгээр хийгдсэн өмд, цамц	
6	Радио идэвхт бодис, рентген цацрагтай харьцах	1. Тугалгадсан өмд, цамц эсвэл хормогч, ханцуйвч 2. Тугалгадсан бээлий 3. Тугалгадсан хушувч 4. Тусгай зориулалтын нүдний шил 5. Хушувч	
7	Цахилгаан гүйдэл, цахилгаан цэнэгтэй харьцах	1. Гүйдэл тусгаарлагч тусгай бээлий 2. Тусгай зориулалтын галош эсвэл бот	
8	Тоостой нөхцөлд	1. Хушувч буюу амны хаалт 2. Ажлын өмд, цамц 3. Хамгаалалтын нүдний шил	
9	Химийн хортой бодистой харьцах	Хуурай нунтаг хортой харьцах	1. Ажлын тусгай комбинзон буюу ажлын тусгай хувцас 2. Ажлын малгай буюу толгойн боолт 3. Ажлын бээлий 4. Ажлын гутал 5. Нүдний шил 6. Хушувч
		Шингэн хортой харьцах	1. Тусгай зориулалтын өмд цамц буюу хормогч 2. Тусгай зориулалтын бээлий 3. Тусгай зориулалтын гутал 4. Ажлын малгай буюу толгойн боолт 5. Хушувч 6. Нүдний шил
10	Гоц халдварт болон байгалийн голомтот үүсгэгч биологийн хортой халдварт биегтэй харьцах	Гоц халдварт өвчний голомтонд ажиллах үед	1. Тахлын халад /иж бүрэн/ 2. Хошуу алчуур /юүдэн/ 3. Нүдний шил 4. Өмд, цамц /комбинзон/ 5. Оймс 6. Хөвөн, самбай амны хаалт 7. Резинэн бээлий /мэс заслын/ 8. Хулдаасан ханцуйвч 9. Хулдаасан хормогч 10. Гарын алчуур

14 дүгээр зүйл. Эрүүл мэндийн үзлэг

ХАБЭА-н хуулийн 14 дүгээр зүйл

14.1. Ажил олгогч нь эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тогтоосон журмын дагуу үйлдвэрлэл, ажил, үйлчилгээтэй холбоотой, зайлшгүй шаардлагатай эрүүл мэндийн урьдчилсан ба хугацаат үзлэгт ажилтныг хамруулна.

14.2. Энэ хуулийн 14.1-д заасны дагуу эрүүл мэндийн үзлэг хийлгэхэд шаардагдах зардлыг ажил олгогч хариуцна.

14.3. Энэ хуулийн 4.1-д заасан этгээд гүйцэтгэж буй тухайн ажил, хөдөлмөрт шаардлагатай бол эмнэлгийн үзлэгт орсон байна.

14.4. Ажилтныг эрүүл мэндийн үзлэгт хамруулах журмыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.

Эрүүл мэндийн сайдын А/340 дүгээр тушаал. **“Журам, жагсаалт батлах тухай”** 2014.10.20

- “Эрүүл мэндийн урьдчилсан болон хугацаат үзлэгийн журам”
 - **Урьдчилсан** (*Ажилтан тухайн ажлыг гүйцэтгэхэд ЭМ-ээр тохирох эсэхийг тодорхойлох*)
 - **Хугацаат** (*Ажилтны ЭМ-ийг тандах, ердийн болон МШӨ-нийг эрт үед нь илрүүлэх, Хөдөлмөрийн чадвар алдалтыг бууруулах, урьдчилан сэргийлэх*)



7-оос доошгүй чиглэлээр эмнэлгийн тусламж үйлчилгээг амбулатори болон хэвтэн эмчлэх хэлбэрээр үзүүлэх өмчийн бүх хэлбэрийн эмнэлгийн байгууллага зохион байгуулна.

Нисэхийн сургалтын төв

14 дүгээр зүйл. Эрүүл мэндийн үзлэг

“Хөдөлмөрийн нөхцөлөөс хамааран эрүүл мэндийн үзлэг хийх жагсаалт”

№	Химийн бодисууд	Олон улсын CAS дугаар	Үзлэгийн хугацаа	Эмнэлгийн өвөрмөц нэмэлт шинжилгээнүүд
1.	Ацетальдегид /Acetaldehyde/	00075-07-0	жилд 1 удаа	Бүхэл цусанд химийн нэгдэл/метаболит үзэх Шээс, амьсгалаар гадагшилсан агаарт химийн нэгдэл/метаболит үзэх
2.	Ацетон /Acetone/	00067-64-1	жилд 2 удаа	Бүхэл цусанд химийн нэгдэл/метаболит үзэх Нөлөөллийн үед бүхэл цусанд химийн нэгдэл/метаболит үзэх Амьсгалаар гадагшилсан агаарт химийн нэгдэл/метаболит үзэх Спирометрийн шинжилгээ Шээсэнд химийн нэгдэл/метаболит үзэх
3.	Ацетонитрил /Acetonitrile/	00075-05-8	жилд 2 удаа	Цусанд сүүний хүчилийн рН үзэх Цусанд цианид, бикарбонат үзэх Амьсгалаар гадагшилсан агаарт химийн нэгдэл/метаболит үзэх Шээсэнд химийн нэгдэл/метаболит үзэх
4.	Ацетиламинофлуорен, 2-/ /Acetylaminofluorene, 2-/	00053-96-3	жилд 2 удаа	Шээсэнд химийн нэгдэл/метаболит үзэх
5.	Ацетилен тетрабромид /Acetylene tetrabromide/	00079-27-6	жилд 2 удаа	Амьсгалаар гадагшилсан агаарт химийн нэгдэл/метаболит үзэх Элэгний үйл ажиллагааны шинжилгээ
6.	Акролин /Acrolein/	00107-02-8	жилд 1 удаа	Цусны хийн шинжилгээ Цээжний рентген зураг Зүрхний цахилгаан бичлэг

“Ажил мэргэжлээс шалтгаалан эрүүл мэндийн үзлэг хийх жагсаалт”

№	Ажил, мэргэжлийн нэр	Үзлэгийн хугацаа	Нэмэлт үзлэг	Нэмэлтээр хийх лабораторийн болон үйл ажиллагааны шинжилгээ
1.	Өндөрт ажиллах, өндөрт авирах ажлууд, өргөх байгууламжийн үйлчилгээний ажлууд	Жилд 1 удаа	*Сэтгэцийн үзлэг	Хараа шалгах Харааны талбай тодорхойлох Сонсгол шалгах Тэнцвэрийн эрхтний үйл ажиллагаа шалгах
2.	12 В тогтмол гүйдэл, 36В дээш хувьсах гүйдлийн хүчдэл бүхий цахилгаан төхөөрөмж, Суурьлагдсан цахилгаан тоног төхөөрөмжтэй харьцаж ажилладаг ажилчид	2 жилд 1 удаа	*Сэтгэцийн үзлэг	Хараа шалгах Харааны талбай шалгах Тэнцвэрийн эрхтний үйл ажиллагаа шалгах Сонсгол шалгах Харааны өнгө шалгах
3.	Гадаа гүйцэтгэдэг ажлууд	Жилд 1 удаа	*Амны хөндийн үзлэг *Сэтгэцийн үзлэг	Хараа шалгах Спирометрийн шинжилгээ Тэнцвэрийн эрхтний үйл ажиллагаа шалгах Сонсгол шалгах Капиллярскопии Цусны дэлгэрэнгүй шинжилгээ Коагулаграмм
4.	Тэсрэмтгий, шатамхай химийн бодис, материалтай харьцан ажиллах ажлууд	Жилд 1 удаа	*Сэтгэцийн үзлэг	Спирометрийн шинжилгээ Тэнцвэрийн эрхтний үйл ажиллагааны шинжилгээ
5.	Галт зэвсэгтэй харьцаж ажилладаг ажлууд	Жилд 1 удаа	*Сэтгэцийн үзлэг	Нүдний хараа шалгах Харааны талбай Сонсгол шалгах Тэнцвэрийн эрхтний үйл ажиллагааны шинжилгээ

“Тэтгэврийг хөнгөлөлттэй тогтоох газрын дор болон хөдөлмөрийн хортой, халуун, хүнд нөхцөлд хамаарах ажил, мэргэжлийн жагсаалтыг шинэчлэн батлах тухай”

Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын №77 дугаар тушаал. 2004.05.03

Нэмэлт өөрчлөлтүүд:

- Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 12 дугаар тушаал. 2007.01.25
- Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын А/26 дугаар тушаал. 2011.02.15
- Хөдөлмөрийн сайд, Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдын хамтарсан А/133, А/77 дугаар тушаал. 2016.07.06
- Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын А/296 дугаар тушаал. 2019.09.19

1-Р АНГИ

• ТОХИРОМЖТОЙ

2-Р АНГИ

• ЗӨВШӨӨРӨХ НӨХЦӨЛ

3-Р АНГИ

• ХОРТОЙ НӨХЦӨЛ

- 1-Р ЗЭРЭГ /3.1/
- 2-Р ЗЭРЭГ /3.2/
- 3-Р ЗЭРЭГ /3.3/
- 4-Р ЗЭРЭГ /3.4/

4-Р АНГИ

• АЮУЛТАЙ

1-р бүлэг

- Газар доорх уурхайн ажил мэргэжил

2-р бүлэг

- Хөдөлмөрийн хортой нөхцөл

3-р бүлэг

- Хөдөлмөрийн халуун нөхцөл

4-р бүлэг

- Хөдөлмөрийн хүнд нөхцөл

17 дугаар зүйл. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн болон мэргэжлийн сургалт



Ажил олгогч нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаархи сургалтыг жилд хоёроос доошгүй удаа зохион байгуулж, нийт ажилтныг хамруулан, шалгалт авч байна



Үйлдвэрлэлийн хортой, аюултай хүчин зүйлийн үйлчлэл бүхий **эрсдэлтэй ажлын байранд** зохих сургалтанд хамрагдан дадлага хийж шалгалтанд тэнцсэн ажилтныг ажиллуулна



Ажил, хөдөлмөр эрхэлж байгаа иргэн, ажилтан болон ажил олгогч нь хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан журмын дагуу хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтад хамрагдаж мэдлэг, дадлагатай болсон байна

“Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт зохион байгуулах, шалгалт авах журам батлах тухай”

Хөдөлмөрийн сайдын А/370 дугаар тушаал. 2019.12.13

ХААЭА-н сургалтын зохион байгуулалт. Үндсэн дүрэм MNS 4969:2000 стандартаас:

Энэ стандартад “үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллага дахь хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн сургалтыг зааварчилгаа өгөх хэлбэрээр зохион байгуулна” гэж заасан. Үүнд:

- 1.Урьдчилсан зааварчилгаа
- 2.Ажлын байран дахь анхан шатны зааварчилгаа
- 3.Давтан зааварчилгаа

Нисэхийн сургалтын төв

Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн сургалтын зохион байгуулалт. Үндсэн дүрэм MNS 4969:2000 стандартаас:

Урьдчилсан зааварчилгыг
ХАБЭА-н танхимд уг асуудлыг хариуцсан ажилтан өгнө.

Урьдчилсан зааварчилгаа нь хөдөлмөрийн хууль тогтоомж, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн дүрэм, заавар, улсын стандарт, тухайн байгууллагын өвөрмөц онцлог, дотоод журам, техникийн аюулгүй ажиллагаа, үйлдвэрлэлийн эрүүл ахуй, ариун цэвэр, галын аюулгүй байдал, хувийн хамгаалах хэрэгсэл, үйлдвэрлэлийн осол, МШӨ, хурц хордлого, үүсэх шалтгаан, осолдогчдод үзүүлэх анхан шатны тусламж зэрэг болно.

Ажлын байран дахь анхан шатны зааварчилгыг
ажлын байрыг хариуцсан цех, тасаг, хэлтсийн дарга, эрхлэгч биечлэн үзүүлэх журмаар өгнө.

Ажлын байран дахь анхан шатны зааварчилгыг ажилтны ажилладаг хэсэг, цех, тасаг, ажлын байр өөрчлөгдөх үед мөн ажилд шинээр орсон болон үйлдвэрлэлийн дадлага хийхээр ирж урьдчилсан зааварчилга авсан хүмүүс, оюутан сурагчдад өгнө. Ажлын байран дахь анхан шатны зааварчилгад тухайн ажилтны ажлын байрны үйлдвэрлэлийн процесс, гүйцэтгэх ажлын онцлог, машин техник, багаж, хэрэгсэл, ашиглах болон ажлын явцад үүсч болох сөрөг хүчин зүйл, түүнээс хамгаалах хэрэгсэл, тэдгээрийг ашиглах заавар, аюулгүйн ажиллагааны арга барил, үйлдвэрлэлийн өргөх тээвэрлэх машин механизм, даралтат сав, шугам хоолой, цахилгаан тоног төхөөрөмжийн ашиглалт, аюулгүй ажиллагааны шаардлага, галын аюулгүй байдлыг хангах журам, гал түймэр гарсан үед авах арга хэмжээ, гал унтраах хэрэгсэл, тэдгээрийг ашиглах, хадгалах, осолдогчдод үзүүлэх анхан шатны тусламж зэрэг болно.

Давтан зааварчилгыг
ажилтанд өмнө олгосон мэдлэгийг бататгах, баяжуулах зорилгоор ажлын байран дахь анхан шатны зааварчилгын агуулгаар өгнө.

Давтан зааварчилгаа нь 3 хэлбэртэй байна. Үүнд:

1. Ээлжит,
2. Ээлжит бус,
3. Ажлын байран дахь өдөр тутмын

Ээлжит бус зааварчилгыг шинэ технологи, машин механизм, тоног төхөөрөмж багаж, хэрэгсэл нэвтрүүлэх, хөдөлмөрийн нөхцөл өөрчлөгдөх, ХААЭА-н дүрэм заавар шинэчлэгдэж өөрчлөгдөх үед давтан зааварчилгаа өгөх ээлжит хугацаанаас нь өмнө өгнө. ХААЭА-н дүрэм, зааврыг ноцтой зөрчсөн хүмүүс буюу ҮОМШӨ, хурц хордлого гарсны дараа, мөн нэг сараас илүү хугацаагаар ажлаас хөндийрч яваад эргэж ажилдаа орсон ажилтанд ээлжит бус давтан зааварчилгаа өгнө. Аюултай ажил гүйцэтгэдэг хүмүүст ажлын байран дахь өдөр тутмын зааварчилгаа өгнө. Ажлын байран дахь өдөр тутмын зааварчилгаа нь товч тодорхой байх ба ажил эхлэхийн өмнө бичгээр өгөгдөнө.

Ажилтанд хүлээлгэх хариуцлага:

/Зөрчлийн тухай хуулийн 10.15 дугаар зүйл. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль зөрчих/

- ХАБЭА-н тухай хууль зөрчиж сахин хангуулах үүргээ биелүүлээгүй бол
- ХАБЭА-н стандарт, дүрэм, журам, хангаж ажиллаагүй бол
- Үйлдвэр үйлчилгээний зориулалттай барилга байгууламж барих, машин механизм, тоног төхөөрөмж суурилуулах, тэдгээрийг шинэчлэх, өргөтгөх, ашиглалтанд өгөх, зуух, ДСШХ, ӨЗММ-д тавигдах шаардлагыг хангаж ажиллаагүй бол

Хувь хүнийг 300 нэгж, Хуулийн этгээдийг 3000 нэгжтэй
тэнцэх хэмжээний төгрөгөөр

ТОРГОНО

ҮО, ХХ-ыг нуун дарагдуулсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол

Хувь хүнийг 400 нэгж
Хуулийн этгээдийг 4000 нэгж

ТОРГОНО

Ажилтныг эрүүл мэндийн урьдчилсан ба хугацаат үзлэгт оруулаагүй бол

Хувь хүнийг 75 нэгж
Хуулийн этгээдийг 750 нэгж

ТОРГОНО

АНХААРАЛ ХАНДУУЛСАНД БАЯРЛАЛАА